



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

904 оны 08 дугаар сарын 25 № 54/А0170079
сар 08/60/СТА-ЧИЗ

Улаанбаатар хот

Г Зөрчил арилгах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь цаашид ашиглах боломжгүй болохыг тодорхойлсон барилгыг резидент эмч нарын дотуур байр, сургалт, судалгааны төвийн зориулалтаар ашиглаж байна.

Энэ нь Мэргэжлийн хяналтын байцаагчийн 2015 оны 02-07-94/1425 дугаартай захиргааны акт, Барилгын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.5 "барилга байгууламжийг галын аюулаас урьдчилан сэргийлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн болон экологийн шаардлагыг хангуулах", 46.1.14-д "барилга байгууламжийг ашиглалтын хугацааны 15 жил тутамд барилга, байгууламжийн төлөв байдалд барилгын улсын хяналтын асуудал эрхэлсэн байгууллагаар дүгнэлт гаргуулж, холбогдох арга хэмжээг авах" гэсэн заалтуутай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрхүүйн акт зөрчsen, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоо, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дүнг тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Хөрөнгийн эрүүл ахуй, аюулгүй байдал алдагдсан бодит нөхцөл байдлыг харгалзан хөрөнгө оруулалт, их тэсварын асуудлаар санал боловсруулж холбогдох газарт хүргүүлж, биелээдийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
- Цаашид алдаа зөрчлийг давтаг гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал Б.Нарантуяа, ахлах нягтлан бодогч Б.Очир нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУУАР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

З.М.
Д.Д.

АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Э.ЭНХБААТАР
П.АМАРСАННАА